



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн “Шинэ хөдөө” төслийн зарим тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдээгүй, 7 төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 3 төсөл, арга хэмжээг баталсан байна.

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3-5
Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	Товчилсон үгийн тайлал	6
Аудитын менежер М.Бат-Амгалан	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	7-9
Ахлах аудитор Т.Намжил	Бүлэг 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байгаа ч, хэрэгжүүлэх боломжгүй 1 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 3 төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна	10
Аудитор Б.Одгэрэл Т.Амармэнд	А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг авч байна	10
2022 оны 4 дүгээр сар	А.1.1. Увс аймагт 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцэж байна.	10-11
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317, 70453721, 70453799 дугаарын утсаар харилцана уу.	А.1.2. Төсвийн тухай хуулиар баталсан хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн явуулсан шинээр хэрэгжүүлэх 57 төсөл, арга хэмжээний саналаас 5 төсөл, арга хэмжээ батлагджээ.	11-12
	А.1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Сангийн яамны эрэмбэд тусгагдсан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн явуулсан 5 төсөл, арга хэмжээний санал батлагджээ.	13-15
Хаяг: Увс аймгийн Аудитын газар Улаангом сум 3 дугаар баг, аймгийн Засаг даргын тамгын газрын байр	А.2. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо бүрдсэн ч он дамжин хэрэгжиж байгаа төсөв өртөг нэмэгдсэн 1 төсөл, арга хэмжээний нэмэгдсэн төсөв нь магадлалаар баталгаажуулсан байна.	16
	А.2.1. Барилга байгууламжийн зураг төсөл зохиох ажлын даалгаврыг орон нутгийн хэрэгцээ шаардлага, инженер геологийн дүгнэлт, бусад холбогдох техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл зэргийг үндэслэж боловсруулсан байна.	16-17
	А.2.2. Барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээд боловсруулж, баталгаажуулсан байна.	17-18
	А.2.3. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад олгосон зардлыг бодит гүйцэтгэл болон зургийн жишиг үнийг үндэслэсэн олгожээ.	18-19
	А.2.4. Барилга байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм, төсвийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар баталгаажуулсан боловч он дамжин хэрэгжиж байгаа төсөвт өртөг нэмэгдсэн 1 төсөл, арга хэмжээний нэмэгдсэн төсөв нь магадлалаар баталгаажуулсан байна.	19-21

	A.2.5. Барилга байгууламжийн ажлын зургийг эх загвар зургийн дагуу норм ба дүрэм, стандартын дагуу боловсруулсан эсэхийг мэргэжлийн экспертүүд үнэн зөв хянаж, магадлалын ерөнхий дүгнэлтийг баталгаажуулсан эсэхийг нарийн мэргэжлийн хөндлөнгийн шинжээч авч ажиллуулаагүй учир тогтоох боломжгүй байна.	21
	A.3. Орон нутагт хэрэгцээ шаардлагатай боловч хэрэгжүүлэх боломжгүй 1 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 3 төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна	21
	A.3.1. Орон нутагт хэрэгцээ шаардлагатай боловч хэрэгжүүлэх боломжгүй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөн баталсныг хэрэгжүүлээгүй байна.	21-23
	A.3.2. Шинээр хэрэгжүүлэх зураг төсөв боловсруулах шаардлагатай 19 төсөл, арга хэмжээнээс 2 ажлын зураг төсвийг хууль батлагдахаас өмнө, 17 ажлын зураг төсвийг хууль батлагдсаны дараа боловсруулж, баталгаажуулсан байна.	23-24
	A.3.3. Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжих зардлыг батлуулсан байна.	24
	A.3.4. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 3 төсөл, арга хэмжээг баталсан байна.	24-25
	Б.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 7 төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, зарим тоног төхөөрөмжийг хэрэглэгчид бүрэн нийлүүлээгүй байна.	25
	Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж байгаа ч сонгон шалгаруулалттай холбоотой 2 худалдан авах ажиллагаанд оролцогч гомдол гарсныг Сангийн яамнаас үндэслэлтэй гэж үзжээ.	25
	Б.1.1. Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.	25-26
	Б.1.2. Төсөл, арга хэмжээний зураг төсөв, техникийн тодорхойлолт батлагдаж гараагүй, зарим төсөл, арга хэмжээнд оролцогч ирээгүй, шаардлага хангахгүй зэрэг шалтгаанаар худалдан авах ажиллагаа оройтож явагдсанаас хугацаа алджээ.	26-27
	Б.1.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулж, батлуулж, хэрэгжүүлсэн байна.	27
	Б.1.4. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан ч, сонгон шалгаруулалттай холбоотой 2 гомдол гарсан нь үндэслэлтэй байжээ.	27-28
	Б.1.5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнаж, шилэн дансанд тавьж, нийтэд мэдээлсэн байна.	29
	Б.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 7 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч захиалагчтай байгуулсан гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, зарим тоног төхөөрөмжийг хэрэглэгчид бүрэн нийлүүлээгүй, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй байна.	30

	Б.2.1. Хөрөнгө оруулалтын 7 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч захиалагчтай байгуулсан гэрээний хугацаанд гүйцэтгээгүй байна.	30-31
	Б.2.2. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналт үр дүнтэй хэрэгжсэн байна.	31-32
	Б.2.3. Хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн зарим тоног төхөөрөмжийг хэрэглэгчид бүрэн нийлүүлээгүй, хүлээлгэн өгөөгүй байна.	32
	Б.2.4. Өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон 1 барилга, байгууламж байна.	33
	Б.2.5. Хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн ТЭЗҮ-ийг мөрдөгдөж байгаа хууль, барилгын норм, дүрэм, стандартын дагуу боловсруулж, 2021 онд хэрэгжүүлсэн, 2022 онд хэрэгжүүлэх 2 барилга байгууламжийн ТАХ-нд ашигласан байна.	33-34
	Б.3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг хэрэгжүүлж байгаа ч үе шатны ажил бүр дээр нарийн мэргэжлийн мэргэжилтнийг оролцуулан хяналт хийдэггүй, зохиогчийн хяналтын гэрээг ТЭЗ-тай байгуулаагүй байна.	34
	Б.3.1 ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн үе шатны хяналтыг тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлсэн ч үе шатны ажил бүр дээр нарийн мэргэжлийн мэргэжилтнийг оролцуулан хяналт хийдэггүй, зохиогчийн хяналтын гэрээг ТЭЗ-тай байгуулаагүй байна.	34-36
	Б.3.2. Эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгосон байна.	36-37
	Б.3.3. Хөрөнгө оруулалтын үйл явцад ТЭЗ-ын дотоод хяналтыг 2 удаа хэрэгжүүлсэн байна.	37
	Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гарсан шийдвэр үр дүнтэй байна.	37
	Б.4.1. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд 10 төсөл, арга хэмжээний 1,900.5 сая төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлжээ.	37-38
	Б.4.2. 2020 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан 12 төсөл, арга хэмжээний 1,433.9 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлснийг бүрэн олгожээ.	38-39
	Б.4.3. 2021 онд байнгын ашиглалтад орсон зарим барилга байгууламж, Төрийн өмчийн хорооны шийдвэр ирээгүйгээс данс бүртгэлд тусгаагүй, барилга байгууламж, зарим техник тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байна.	39-41
	Б.4.4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг 60 хувьтай, албан шаардлагыг 100 хувьтай хэрэгжүүлжээ.	41-42
	Дүгнэлт	44
	Холбогдох байгууллагын санал	45
	Аудитын газраас өгөх тайлбар	46
	Зөвлөмж	47-48

Товчилсон үгийн тайлал:

УВА	Увс аймаг
ШТА	Шууд тайлагнах аудит
ГА	Гүйцэтгэлийн аудит
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТАХ	Төсөл арга хэмжээ
УИХ	Улсын их хурал
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын төлөвлөгөө батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаал, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийсэн. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, төсөл арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх.

Хамарсан хүрээ

Аудитыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэхээр Төсвийн тухай хуулиар баталсан 48 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн хийсэн.

Аудитад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд санхүүжүүлэхээр баталсан 48 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн Засаг дарга болон түүний харьяа байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч зарим аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулсан.

Арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” MNS 6817-8:2020, “Төрийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-ын аудит хийх журам, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан

тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Гүйцэтгэлийн аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын арга зүйгээр хангаж, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Намжил, аудитор Б.Одгэрэл, Т.Амармэнд нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын хөтөлбөрт тусгагдсан цаглаварт хугацаанд Санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл, нийцлийн төлөвлөгөөт аудитууд зэрэг хийгдсэнээс шалтгаалан Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрийг газар дээр нь очиж үзэж амжаагүй болно. Аудитын хүрээнд Улаангом сум болон хөдөөгийн 8 суманд очиж ажилласан бөгөөд бусад суманд хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг онлайнар фото зураг, тайлбар, зөрчлийн тэмдэглэл гаргуулан авч тулган баримтжууллаа.

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан он дамжин хэрэгжүүлж байгаа 3 төсөл, арга хэмжээнд нарийн мэргэжлийн компанийг гэрээний үндсэн дээр ажиллахаар УАГ-т санал хүргүүлсэн болно. Үүнд:

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
1	III.1.1.14	Усан бассейн, спорт фитнесийн барилга /Увс, Улаангом сум/	2019	2021	4,100.0	500.0
2	XIV.1.3	Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/	2019	2022	10,526.6	500.0
3	XIII.1.1.78	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Увс, Тэс сум/	2020	2021	4,200.0	3,400.0

/сая төгрөг/

/Эх сурвалж: Увс аймаг дахь Төрийн аудитын газраас УАГ-т хүргүүлсэн санал/

Аудитын дүн

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн аудитаар 5 зөвлөмж өглөө. Мөн Үндэсний аудитын газарт 4 санал хүргүүлсэн болно.

Ерөнхий зүйл

Улсын Их Хурлаар 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 24 ТЕЗ-ийн төсвийн багцад 3,763.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1100 төсөл, арга хэмжээний 1,390.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталсан байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд Улсын Их Хурлын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн оруулсан өөрчлөлтөөр шинээр эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 110.0 тэрбум төгрөгөөр, мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээний төсөвт өртөг,

санхүүжих дүнг 8.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, 22 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 90.0 тэрбум төгрөгөөр бууруулсан байна.

Төсөвт хийсэн тодотголоор 2021 онд өмнөх оноос он дамжин үргэлжлэн хэрэгжиж буй 643, шинээр 458, нийт 3,881.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,101 төсөл, арга хэмжээг 1,418.9 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Нийт санхүүжилтийн 76.5 хувийг 789 барилга, байгууламж, 14.2 хувийг 119 тоног төхөөрөмж, 6 хувийг 166 их засвар, 3.3 хувийг 27 ТЭЗҮ боловсруулах төсөл арга хэмжээнд тус тус зарцуулахаар байна.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг салбараар нь ангилж үзвэл нийгмийн салбарт 49.3 хувийг, дэд бүтцийн салбарт 34.4 хувийг, бусад салбарт 11.9 хувийг, хууль сахиулах, батлан хамгаалах салбарт 4.4 хувийг зарцуулахаар тус тус хуваарилсан байна.

Батлагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 1,311.4 тэрбум төгрөгийг олгож, 92.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 87.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 211 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Засгийн газрын шийдвэр болон Төсвийн ерөнхийлөн захирагчдын шийдвэрээр орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 10.1.14, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.3-т заасныг тус тус үндэслэн Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 397 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үлдэгдлийг Төсвийн ерөнхийлөн захирагчдын барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

Увс аймагт Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар 66,353.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 48 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 2021 онд олгох санхүүжилт нь 21,181.0 сая төгрөг байна.

Хэрэгжих хугацааны хувьд 2019-2021 онд хэрэгжүүлэх 1 төсөл, арга хэмжээ, 2019-2022 онд хэрэгжүүлэх 3 төсөл, арга хэмжээ, 2020-2021 онд хэрэгжүүлэх 13 төсөл, арга хэмжээ, 2020-2022 онд хэрэгжүүлэх 1 төсөл, арга хэмжээ, 2021 онд хэрэгжүүлэх 16 төсөл, арга хэмжээ, 2021-2022 онд хэрэгжүүлэх 12 төсөл, арга хэмжээ, 2021-2023 онд хэрэгжүүлэх 2 төсөл, арга хэмжээ тус тус байна.

Үүнд: Барилга байгууламж 21, засварын ажил 6, зам, гүүр барих 2, цахилгааны шугамын ажил 2, Харилцаа холбооны дахин дамжуулах станц 1, нийтийн эзэмшлийн зам, талбай тохижуулах ажил 2, сумын төвийн тохижилт 2, Таван суманд жуулчдад мэдээлэл өгөх цэг, отголох талбай байгуулах 1, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийлгэх 5, авто парк шинэчлэлийн 2, Сумын хэрэгцээнд универсал трактор 3, шинэ хөдөө төслийн хүрээнд хийгдэх 3 төсөл, арга хэмжээ багтжээ.

БҮЛЭГ: 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байгаа ч, хэрэгжүүлэх боломжгүй 1 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 3 төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна.

А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг авч байна.

А.1.1. Увс аймагт 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцэж байна.

Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт “Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг дараах зүйлийг харгалзан тогтооно”, 28.3.8 дахь заалтад “орон нутгийн хөгжлийн хэрэгцээ”, 28.3.9 дэх заалтад “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл”, 28.5 дахь хэсэгт “Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төслийг энэ хуулийн 28.3.9, 28.3.11-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулна” гэж заасан байна.

Мөн УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.2-д “Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендерийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрд хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ” гэсэн заалттай Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд Увс аймагт хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нийцэж байна.

Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан ТАХ-г эрэмбэлэх журмын 1.1-д “Энэхүү журмын зорилго нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй болон шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээг тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу судлан шинжилж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төслийн бэлэн байдлаар нь эрэмбэлсний үндсэн дээр улсын төсөвт тусгах шийдвэр гаргах, төсвийн зардлыг бууруулах, төсвийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгоход оршино” гэж тодорхойлсон байна.

Увс аймагт Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар 66,153.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 48 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 2021 онд олгох санхүүжилт нь 21,181.0 сая төгрөг байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хийгдэхээр батлагдсан 48 төсөл, арга хэмжээний хувьд УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан

“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.2-д тусгасан Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн ажлууд байна. Тухайлбал:

- Бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах,
- Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх,
- Иргэн бүрд хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх,
- Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлууд байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламж нь Увс аймгийн Хөгжлийн стратеги төлөвлөгөө /2008-2021/, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй нийцэж байна.

А.1.2. Төсвийн тухай хуулиар баталсан хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн явуулсан шинээр хэрэгжүүлэх 57 төсөл, арга хэмжээний саналаас 5 төсөл, арга хэмжээ батлагджээ.

Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх жилийн төсвийн хязгаар нь дараах шаардлагыг хангасан байна”, 27.2.2 дахь заалтад “хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах шинээр болон үргэлжлэн хэрэгжих төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрээр ангилан тусгах” гэж заажээ.

Мөн Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь энэхүү журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 3.2.1-д “төсөл, арга хэмжээний саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх”, 3.2.2-д “төсөл, арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн улсын төсвөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах”, 3.2.3-д “энэ журамд зааснаар үнэлж, эрэмбэлсний дагуу тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг улсын төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлэх” гэж заасны дагуу Увс аймгийн Засаг дарга 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 1/585 дугаар бичгээр шилжин хэрэгжүүлэх болон шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг салбар яамдын сайд нарт хүргүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр 190,769.3 сая төгрөгийн 57 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн саналыг жагсаалтаар хүргүүлсэн байна. Үүнд:

			/сая.төгрөг/
Д/д	Яамны нэр	Төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн саналын тоо	Мөнгөн дүн
1	Шадар сайд	2	1,801.0
2	Засгийн газрын хэрэг эрхлэх асуудлын хүрээнд	6	10,800.0
3	ХЗДХЯ	2	25.5
4	Барилга хот байгуулалтын яам	5	1,150.0
5	Эрчим хүчний яам	1	200.0
6	Зам тээвэр хөгжлийн яам	5	127,054.2
7	Эрүүл мэндийн яам	4	3,250.0
8	БШУЯам	16	26,650.0
9	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам	2	1,020.0
10	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам	8	10,876.8
11	Байгаль орчин аялал жуулчлалын яам	6	492.8
	Нийт	57	183,320.3

/Эх сурвалж: Увс аймгийн Засаг даргын 2021 оны төсвийн төслийн санал/

Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан ТАХ-г эрэмбэлэх журам, аргачлал, дахин үнэлэх аргачлал, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлалын 3.1-д “Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төслийн төлөвлөлт, төсөвлөлт, удирдлага, зохион байгуулалтыг хариуцаж ажиллах бөгөөд энэхүү журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 3.1.1-д “төслийн саналыг энэ журамд заасны дагуу хүлээн авах нэгтгэх”, 3.1.2-д төслүүдийг энэ журамд заасны дагуу эрэмбэлэн улсын төсвөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төслийг тодорхойлох, санал дүгнэлтийг гаргах”, 3.1.3-д “шалгуур хангасан төсөлд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар болон төсвийн төсөлд тусгуулах” гэж заасан байна.

Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуулиар баталсан 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн саналаас 3,810.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээний санал батлагдсан байна.

Салбарын хувьд БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 4 төсөл, арга хэмжээ, БХБЯ-ны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1 төсөл арга хэмжээг батлагдаж ирсэн байна. Үүнд:

- ❖ Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Увс, Улаангом сум, 6 дугаар баг, 8 дугаар цэцэрлэг/
- ❖ Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Увс, Ховд сум/
- ❖ Цэцэрлэгийн барилгын өргөтгөл 50 ор, их засвар /Увс, Давст сум/
- ❖ Дотуур байрын барилгын их засвар /Увс, Хяргас сум/
- ❖ Багийн тохижилт, гэрэлтүүлэг, камержуулалт /Увс, Улаангом сум, 9 дүгээр баг/

А.1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Сангийн яамны эрэмбэд тусгагдсан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн явуулсан 5 төсөл, арга хэмжээний санал батлагджээ.

Харин Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь энэхүү журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 3.2.1-д “төсөл, арга хэмжээний саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх”, 3.2.2-д “төсөл, арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн улсын төсвөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах”, 3.2.3-д “энэ журамд зааснаар үнэлж, эрэмбэлсний дагуу тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг улсын төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлэх” гэж заасан байна.

Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагч Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал хүргүүлэхдээ нийт сумдын болон багийн Иргэдийн нийтийн хурлын саналыг авч аймгийн Засаг даргын тамгын газарт эрэмбэ тогтоож, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан эрэмбэлж төлөвлөсөн байна.

Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуулиар баталсан Увс аймагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн судалгаа:

/сая төгрөг/

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
1	III.1.1.12	Спорт цогцолборын барилга /Увс, Тариалан сум/	2020	2022	1,150.0	850.0
2	III.1.1.14	Усан бассейн, спорт фитнесийн барилга /Увс, Улаангом сум/	2019	2021	4,100.0	500.0
3	III.1.1.23	Спорт заалны барилга /Увс, Малчин сум/	2021	2022	950.0	150.0
4	III.1.1.24	Спорт заалны барилга /Увс, Хяргас сум/	2021	2022	950.0	150.0
5	V.3.1.8	Харилцаа холбооны дахин дамжуулах станц /Увс, Өмнөговь сум, Улиаст баг/	2021	2021	250.0	250.0
6	VI.1.13	Жуулчдад мэдээлэл өгөх цэг, отоглох талбай байгуулах /Увс, Малчин, Завхан, Наранбулаг, Хяргас, Цагаанхайрхан сум/	2021	2021	500.0	500.0
7	VI.4.1	Усны нөөц, усжуулалтын чанарын техник, эдийн засгийн үндэслэл /Увс/	2021	2021	200.0	200.0
8	IX.3.1.1	Татварын хэлтсийн барилга /Улаанбаатар, Хөвсгөл, Увс, Баянхонгор/	2020	2021	2,100.0	1,000.0
9	X.2.1.2	Хилийн цэргийн 0245 дугаар ангийн соёлын төвийн барилгын өргөтгөл /Увс, Улаангом сум/	2021	2021	350.0	350.0

10	X.2.2.1	Хилийн цэргийн 0245 дугаар ангийн барилгын их засвар /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/	2020	2021	150.0	50.0
11	X.4.3.3	Аймгийн цагдаагийн газрын авто парк шинэчлэл /Увс, Улаангом сум/	2021	2022	160.0	80.0
12	XI.2.1.1	Оюутны дотуур байрын барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/	2019	2022	6,369.8	500.0
13	XII.1.97	Сумын төвийн тохижилт /Увс, Улаангом сум/	2021	2023	7,800.0	1,800.0
14	XII.1.99	Сумын төвийн тохижилт /Увс, Түргэн сум/	2021	2022	1,400.0	100.0
15	XII.1.100	Ухаалаг худаг бүхий нийтийн халуун усны барилга /Увс, Зүүнхангай сум/	2021	2022	340.0	50.0
16	XII.2.3	Наадмын талбайн тохижилт /Увс, Улаангом сум/	2020	2021	1,000.0	500.0
17	XII.2.7	Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын гадна фасад, дулаалгын засвар /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/	2020	2021	1,330.0	930.0
18	XII.2.8	Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дээврийн засвар /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/	2020	2021	830.0	530.0
19	XII.2.41	Нийтийн халуун усны барилгын их засвар /Увс, Бөхмөрөн сум/	2021	2021	50.0	50.0
20	XII.2.43	Багийн тохижилт, гэрэлтүүлэг, камержуулалт /Увс, Улаангом сум, 9 дүгээр баг/	2021	2021	300.0	300.0
21	XII.3.3	Хог тээврийн авто машин /Увс, Бөхмөрөн сум/	2021	2021	30.0	30.0
22	XII.3.4	Сумын хэрэгцээнд универсал трактор /Увс, Цагаанхайрхан сум/	2021	2021	120.0	120.0
23	XII.3.5	Сумын хэрэгцээнд универсал трактор /Увс, Өндөрхангай сум/	2021	2021	120.0	120.0
24	XII.3.6	Сумын хэрэгцээнд универсал трактор /Увс, Зүүнхангай сум/	2021	2021	120.0	120.0
25	XII.4.4	Бизнес инкубатор төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом сум/	2021	2021	100.0	100.0
26	XIII.1.1.16	Дотуур байрын барилга, 100 ор /Увс, Ховд сум/	2020	2021	1,300.0	1,200.0
27	XIII.1.1.62	Сургуулийн барилга, 640 суудал /Увс, Наранбулаг сум/	2019	2022	4,239.0	500.0
28	XIII.1.1.78	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Увс, Тэс сум/	2020	2021	4,200.0	3,400.0
29	XIII.1.1.11 6	Сургуулийн спорт заалны барилга /Увс, Сагил сум/	2020	2021	1,150.0	700.0
30	XIII.1.1.17 3	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Увс, Улаангом сум, 3 дугаар баг, 5 дугаар цэцэрлэг/	2020	2021	890.0	690.0
31	XIII.1.1.18 3	Япон Улсын "Өвсний үндэс" хөтөлбөрийн үлдэгдэл санхүүжилт-сургуулийн урлаг, дизайны заалны	2020	2021	651.0	551.0

		өргөтгөл /Увс, Улаангом сум, 4 дүгээр сургууль/				
32	XIII.1.1.25 9	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл 50 ор, их засвар /Увс, Давст сум/	2021	2022	950.0	300.0
33	XIII.1.1.26 2	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Увс, Улаангом сум, 6 дугаар баг, 8 дугаар цэцэрлэг/	2021	2022	900.0	130.0
34	XIII.1.1.26 3	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Увс, Ховд сум/	2021	2022	960.0	300.0
35	XIII.1.2.54	Дотуур байрын барилгын их засвар /Увс, Хяргас сум/	2021	2022	700.0	350.0
36	XIII.1.3.7	Сургуулийн дунд оврын автобус /Увс, Өлгий сум/	2021	2021	50.0	50.0
37	XIV.1.3	Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/	2019	2022	10,526.6	500.0
38	XV.1.1.32	Сумын төвөөс Хархираа баг хүртэлх сайжруулсан шороон зам, 25 км /Увс, Тариалан сум/	2020	2021	200.0	100.0
39	XV.2.1.1	Модон гүүр /Увс, Завхан сум, Хармагт баг/	2020	2021	300.0	180.0
40	XVII.3.5	"Шинэ хөдөө" төсөл /Увс/	2021	2023	4,500.0	650.0
41	XVII.4.1	Баруун бүсийн логистик төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом сум/	2021	2021	250.0	250.0
42	XVII.4.2	Цагаан ултай гутлын кластер төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс/	2021	2021	100.0	100.0
43	XVII.4.3	Гурил, тэжээлийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом, Баруунтуруун сум/	2021	2021	200.0	200.0
44	XVIII.1.1	0.4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл /Увс, Улаангом сум, 12 дугаар баг/	2020	2021	300.0	150.0
45	XVIII.1.24	Сумын төвийн цахилгааны шугамыг СИП кабелиар солих /Увс, Баруунтуруун сум/	2021	2022	320.0	150.0
46	XIX.1.37	Эрүүл мэндийн төвийн барилга /Увс, Тэс сум, Хар үзүүр, Таван улиас баг/	2021	2021	200.0	200.0
47	XIX.1.54	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, их засвар /Увс, Наранбулаг сум/	2021	2022	860.0	300.0
48	XXII.1.8	Прокурорын газрын барилга /Увс, Улаангом сум/	2021	2022	1,837.0	900.0
		НИЙТ			66,353.4	21,181.0

/Эх сурвалж: Монгол улсын 2021 оны төсвийн тухай хууль/

Дээрх 48 төсөл, арга хэмжээнд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн салбар яамдад хүргүүлсэн саналд тусгагдсан 57 төсөл, арга хэмжээнээс 5 төсөл, арга хэмжээ батлагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэхээр төсвийн тухай хуулиар батлагдсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг өмнөх оны

хөрөнгө оруулалттай харьцуулахад 20 төсөл, арга хэмжээгээр буюу санхүүжилтийн хувьд 39,382.3 сая төгрөгөөр буурсан байна.

А.2. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо бүрдсэн ч он дамжин хэрэгжиж байгаа төсөв өртөг нэмэгдсэн 1 төсөл, арга хэмжээний нэмэгдсэн төсөв нь магадлалаар баталгаажаагүй байна.

А.2.1. Барилга байгууламжийн зураг төсөл зохиох ажлын даалгаврыг орон нутгийн хэрэгцээ шаардлага, инженер геологийн дүгнэлт, бусад холбогдох техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл зэргийг үндэслэж боловсруулсан байна.

Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх хэсэгт “Эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж тухайн ашиглагч байгууллагын саналыг үндэслэн барилга байгууламжийн зураг төсөл зохиох ажлын даалгаврыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас төсөл, арга хэмжээ бүрд боловсруулж, инженер геологийн дүгнэлт, бусад холбогдох техникийн нөхцлүүдийг гаргуулах талаар барилга байгууламжийн зураг төсөл зохиох ажлын даалгаварт тусгажээ. Түүнчлэн газар олгох захирамжийг өмнөх онд төлөвлөгөөнд тусгаж батлуулсны үндсэн дээр газар олголтыг хийдэг байна.

Түүнчлэн барилга байгууламжийн зураг төсөл зохиох ажлын даалгаврыг боловсруулахдаа төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх газар дээр нь очиж орон нутгийн хэрэгцээ шаардлагыг тогтоон боловсруулан холбогдох бичиг баримтыг гаргуулан зураг төсвийг хийлгүүлжээ.

Мөн Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9 дэх хэсэгт “Доорх барилга байгууламжийн зураг төслийн даалгавар, норм, нормативын баримт бичгийн техникийн даалгаврыг холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хянуулсан байна” гэж заасны дагуу аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээр хянуулж аймгийн Засаг даргаар батлуулжээ.

Барилгын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэгт “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах үе шатыг зураг төслийн байгууллагатай байгуулсан гэрээ болон зургийн даалгаварт тусгана” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллажээ.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд шинээр болон үргэлжлэн хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бэлтгэнэ. Түүнчлэн энэ хуулийн 28.1-д зааснаас бусад, нийт төсөвт өртөг нь 30.0 тэрбум төгрөгөөс бага өртөгтэй хөрөнгө оруулалтын төслийн саналыг төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдамжид заасны дагуу тус тус бэлтгэж үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад энэ хуулийн 8.4.3-т заасан хугацаанд ирүүлнэ” гэж заасны дагуу хүргүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 33.2.6 дахь заалтад “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал,

хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүнг төсөвт тусгаж батална” гэж заасныг зөрчиж Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуулиар баталсан XVII.3.5 хуулийн дугаартай 2021-2023 онд хэрэгжүүлэх нийт 4,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шинэ хөдөө” төсөл гэсэн ажлын нэр, байршил, хүчин чадлыг тусгаагүй байх бөгөөд Монгол улсын Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолоор 2021 онд санхүүжүүлэх 650.0 сая төгрөгийн эрхийг шилжүүлсэн байна.

Эрх шилжүүлсний дагуу аймгийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн А/235 дугаар захирамжаар “Шинэ хөдөө” төслийн эх үүсвэр 650.0 сая төгрөгийг дараах байдлаар задалж нэр, байршил, хүчин чадлыг тусгаж баталсан байна. Үүнд:

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх дуусах хугацаа	Төсөвт өртөг	/сая.төгрөг/ 2021 онд санхүүжих дүн
1	Сүү, цагаан идээ боловсруулах цех байгуулах /Өндөрхангай, Улаангом/	2021-2021	440.0	440.0
2	Жижиг оврын тэжээл боловсруулах цехийн тоног төхөөрөмж	2021-2021	160.0	160.0
3	Ашиглалтын зардал багатай, эрчим хүч, шатахуун зарцуулдаггүй, хэмнэлттэй, инновацын шийдэлтэй, голоос тариалангийн талбай руу ус шахах төхөөрөмж худалдан авах.	2021-2021	50.0	50.0
	Нийт дүн		650.0	650.0

/Эх сурвалж: аймгийн Засаг даргын захирамж/

Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуульд төсөл нэрээр баталж орон нутагт эрх шилжүүлснээр орон нутгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч багц ажил болгон задалсан нь хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэхийг УАГ-ын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлж байна.

А.2.2. Барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээд боловсруулж, баталгаажуулсан байна.

Барилгын тухай хууль 23 дугаар зүйлд “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах”, 23.4 дэх хэсэгт “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах үе шатыг зураг төслийн байгууллагатай байгуулсан гэрээ болон зургийн даалгаварт тусгана”, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Зураг төсөл зохиогч дараах чиг үүрэгтэй”, 38.1.1 дэх хэсэгт “Барилга байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцүүлэн хөрөнгө оруулалтын үр ашиг болон техникийн тооцоонд тулгуурлан боловсруулах, 38.1.2 дахь заалтад “барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх”, 38.1.3 дахь заалтад “зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль

тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх” гэж заажээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт хэрэгжүүлэх Барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээд ажлын тоо хэмжээ болон зураг төсөл боловсруулах даалгавар, холбогдох бичиг баримтыг үндэслэн боловсруулж, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар болон ерөнхий архитектураар хянуулж Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулсан байна.

А.2.3. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад олгосон зардлыг бодит гүйцэтгэл болон зургийн жишиг үнийг үндэслэсэн олгожээ.

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 30 дугаар тушаалын хоёр дугаар хавсралтаар батлагдсан Барилгын төсөв зохиох дүрмийн 2.11 дэх хэсэгт “Барилгын ажлын төсөвт өртгийг тодорхойлоход барилгын удирдлага, зохион байгуулалтын зардал (нэмэгдэл зардал), төсөвт ашиг ба барилга угсралтын ажлын бусад хязгаар тогтоосон (лимитлэгдсэн) зардлуудын нормативыг ашиглана” Үүнд: “.... Зураг төсөл, инженер геологи ажлын жишиг үнэ.....”, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9.17-д “Зураг төсөл боловсруулсан зардал, зохиогчийн хяналт болон захиалагчийн хяналтын зардлыг тухайн төсөл дээр байгуулсан гэрээ, хийсэн ажлын тайлангийн дагуу холбогдох норм дүрэмд заасныг үндэслэн энэ журмын хавсралт №16-д заасан маягтыг бөглөж олгоно” гэж заасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний зураг төслийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлийг үндэслэн гэрээний дагуу олгосон байна.

Жуулчдад мэдээлэл өгөх цэг, отоглох талбай байгуулах /Увс, Малчин, Завхан, Наранбулаг, Хяргас, Цагаанхайрхан сум/ 500.0 сая төгрөгийн ажилд сум бүрээр салгаж 5 багц болгон тендерийг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулахад зураг төсвийн үнийг шалгарсан компаниуд өөр өөрөөр тооцож төсөвт тусгасан байна. Үүнд:

- Малчин сумын нутагт байрлах отоглох цэгт зураг төсвийн үнийг гүйцэтгэгч тал хариуцах,
- Завхан сумын нутагт байрлах отоглох цэгт зураг төсвийн үнийг 0.95 сая төгрөгөөр,
- Наранбулаг сумын нутагт байрлах отоглох цэгт зураг төсвийн үнийг 1.2 сая төгрөгөөр,
- Хяргас сумын нутагт байрлах отоглох цэгт зураг төсвийн үнийг 4.0 сая төгрөгөөр,
- Цагаанхайрхан сумын нутагт байрлах отоглох цэгт зураг төсвийн үнийг 4.0 сая төгрөгөөр тус тус тусгасан байна.

Цаашид түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр тендер зарлахдаа ижил төстэй ажлын зураг төсвийн үнийг жишиг үнийг баримтлан тендерийн баримт бичигт

тусгаж оруулснаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг хэмнэх боломж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэхээр төсвийн тухай хуульд батлагдсан ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах дараах 5 төсөл, арга хэмжээ байна.

- ✓ Усны нөөц, усжуулалтын чанарын техник, эдийн засгийн үндэслэл /Увс/ 200.0 сая,
- ✓ Бизнес инкубатор төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом сум/ 100 сая,
- ✓ Баруун бүсийн логистик төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом сум/ 250.0 сая,
- ✓ Цагаан ултай гутлын кластер төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс/ 100 сая,
- ✓ Гурил, тэжээлийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом, Баруунтуруун сум/ 200.0 сая

Дээрх 5 төсөл, арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгосон бөгөөд ажил нь дуусаж хүлээн авсан байна.

Харин Баруун бүсийн логистик төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсийн ажлын гүйцэтгэлийг 85 хувьтай гэж үнэлж 211.3 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Уг ажил нь тендер оройтож зарлагдаж он дамжин хэрэгжсэн байх бөгөөд төслийн техник эдийн засгийн үндэслэлийг аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/790 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт танилцуулсан бөгөөд загвар зураг төслийг холбогдох байгууллагаар баталгаажуулан ажиллаж байна.

А.2.4. Барилга байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм, төсвийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар баталгаажуулсан боловч он дамжин хэрэгжиж байгаа төсөвт өртөг нэмэгдсэн 1 төсөл, арга хэмжээний нэмэгдсэн төсөв нь магадлалаар баталгаажгаагүй байна.

Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.10 дахь заалтад “барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэж, холбогдох зардлыг хариуцах” гэж заасны дагуу Барилга байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм төсвийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу хийгдсэн эсэхийг Барилгын хөгжлийн төвийн магадлалын хэлтэст хянуулж баталгаажуулсан байна.

Барилга, байгууламжийн төсөвт өртгийг зохиохдоо Засгийн газрын 2010 оны 336 дугаар “Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ батлах тухай” тогтоолыг мөрдөж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын холбогдох мэргэжилтнүүдийг хамруулсан ажлын хэсэг 2019 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр “Барилга байгууламжийг

өргөтгөх, шинэчлэх, засварлах, тоноглох, буулгалтын ажлын зураг төсвийг магадлалаар оруулах” талаар хуралдаж дараах шийдвэрийг гаргасан байна.

- Барилга байгууламжийн үндсэн хийц бүтцэд өөрчлөлт орсон засварын ажлын зураг төсвийг магадлалд оруулна.
- Барилга байгууламжийн үндсэн хийц бүтцэд өөрчлөлт ороогүй бол засварын ажлын зураг төсөвт магадлал хийлгэхгүй.
- Магадлалыг зураг төсвийн байгууллага хариуцан хийлгэнэ.
- Энэ асуудлыг зураг төсөв боловсруулах гэрээнд заалт болгож оруулахыг захиалагчид даалгах.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд эрх шилжиж хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдээс засварын ажлаас бусад шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн ажлуудад Барилга хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвөөс магадлал хийж ерөнхий дүгнэлт гаргасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2-3 жил дамжин хэрэгжүүлэх томоохон зарим төсөл, арга хэмжээний хувьд төсөвт өртөг барилгын материалын үнэ, ажиллах хүчний зардлын өсөлт, тээврийн зардлын өсөлт, зураг төсөвт тусгагдаагүй нэмэлт ажил гарах зэргээс шалтгаалан төсөв нь нэмэгдсэн байна. Үүнд:

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг			Нэмэгдсэн	Шалтгаан
		2019	2020	2021		
1	Спорт цогцолборын барилга /Увс, Тариалан сум/		950.0	1,150.0	200.0	Барилгын материал, тээврийн зардлын үнийн өсөлт нөлөөлсөн.
2	Оюутны дотуур байрын барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/	4,474.0	4,474.0	6,369.8	1,895.8	Барилгын төсөв зохиох программаар 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс цалингийн зардлыг өсгөж боддог болсон болон материалын үнийн өсөлт нөлөөлсөн.
3	Сургуулийн барилга, 640 суудал /Увс, Наранбулаг сум/	3,892.5	3,892.5	4,239.0	346.5	ТЕЗ-д гүйцэтгэгч компанийн гаргасан хүсэлтийн дагуу Барилгын хөгжлийн төвийн магадлалын дүгнэлтийн дагуу төсвийг нэмсэн.
4	Сургуулийн спорт заалны барилга /Увс, Сагил сум/		900.0	1,150.0	250.0	Барилгын материал, тээврийн зардлын үнийн өсөлт нөлөөлсөн.
5	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Увс, Улаангом сум, 3 дугаар баг, 5 дугаар цэцэрлэг/		770.0	890.0	120.0	Анхны зураг төсөвт тусгагдаагүй гадна инженерийн шугам сүлжээний ажил нэмэлтээр гарч төсөв нэмэгдсэн.

6	Аймгийн хөгжимт драмын “Ойрад” театрын барилга /Увс, Улаангом сум/	6,800.0	6,800.0	10,526.6	3,726.6	Анхны зураг төсөвт тусгагдаагүй гадна тохижилт, гадна тайз, автомашины зогсоол, дотор тоног төхөөрөмжийн ажлууд нэмэлтээр гарч төсөв нэмэгдсэн.
---	--	---------	---------	----------	---------	---

/Эх сурвалж: Монгол улсын 2019, 2020, 2021 оны төсвийн тухай хууль/

Дээрх төсөл, арга хэмжээнээс Улаангом Политехник коллежийн 300 ортой оюутны дотуур байрны барилгын ажил нь анх 2019 онд 4,474.0 сая төгрөгөөр батлагдсан боловч Барилгын төсөв зохиох программаар 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс цалингийн зардлыг өсгөж боддог болсонтой холбоотойгоор 2021 оны Улсын төсөвт 6,369.8 сая төгрөг болгон баталсан байна. Уг ажлын нэмэгдсэн төсөв нь магадлалаар баталгаажуулсан учир аймгийн ТЭЗ-ийн зүгээс гэрээнд өөрчлөлт оруулаагүй байх бөгөөд 2021 онд ямар нэг үйл ажиллагаа явуулаагүй байна.

А.2.5 Барилга байгууламжийн ажлын зургийг эх загвар зургийн дагуу норм ба дүрэм, стандартын дагуу боловсруулсан эсэхийг мэргэжлийн экспертүүд үнэн зөв хянаж, магадлалын ерөнхий дүгнэлтийг баталгаажуулсан эсэхийг нарийн мэргэжлийн хөндлөнгийн шинжээч авч ажиллуулаагүй учир тогтоох боломжгүй байна.

Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Барилга байгууламжийн зураг төслийн магадлалыг энэ хуулийн 23.2-т заасан эх загвар зураг /эскиз/ болон ажлын зургийн үе шатуудад ажлын 15 өдөрт багтаан хийнэ”, 39.1 дэх хэсэгт “Барилга байгууламжийн зураг төсөлд хийх магадлалыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 34.1.10-т заасны дагуу эрх олгосон иргэн, хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ”, 39.5 дахь хэсэгт “Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаарх дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ” гэж заажээ.

Мөн Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг, төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийг баталсан байна.

Увс аймагт 2021 оны төсвийн тухай хуульд тусгагдан хэрэгжүүлж байгаа Барилга байгууламжийн ажлын зургийг мэргэжлийн экспертүүд хянаж, магадлалын ерөнхий дүгнэлтийг баталгаажуулсан байна. Ингэхдээ Барилга байгууламжийн ажлын эх загвар зургийн дагуу норм ба дүрэм, стандартын дагуу боловсруулсан эсэх, магадлалын ерөнхий дүгнэлтээр үнэн зөв хянаж баталгаажуулсан эсэхэд аудитаар нарийн мэргэжлийн хөндлөнгийн шинжээч авч ажиллуулаагүй болно.

А.3. Орон нутагт хэрэгцээ шаардлагатай боловч хэрэгжүүлэх боломжгүй 1 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 3 төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна

А.3.1. Орон нутагт хэрэгцээ шаардлагатай боловч хэрэгжүүлэх боломжгүй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөн баталсныг хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэгт “Төсвийн удирдамжид дараах зүйлийг тусгана”, 27.4.4 дэх заалтад “хөрөнгө оруулалтын төсөл боловсруулахад тавигдах ерөнхий болон тусгай шаардлага”, 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт “Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг дараах зүйлийг харгалзан тогтооно”, 28.3.8 дахь заалтад “орон нутгийн хөгжлийн хэрэгцээ” гэж заажээ.

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар орон нутагт хэрэгжүүлэхээр Модон гүүр /Увс, Завхан сум, Хармагт баг/ төсөл, арга хэмжээнд 300.0 сая төгрөг төсөвлөж баталжээ. Аймгийн холбогдох мэргэжилтэн, сумдын удирдлагууд, мэргэжлийн зураг төслийн байгууллагын инженерүүд газар дээр нь очиж гүүр тавих боломжтой цэгийг судлахад Завхан голын хамгийн богино хэсэг нь 250 м өргөн байх бөгөөд мэргэжлийн байгууллагууд нь 300.0 сая төгрөгөөр 250 у/м модон гүүрийг барих боломжгүй гэж үзсэн учир Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 1/288 дугаар албан бичгээр Зам, тээвэр, хөгжлийн яаманд хандсан байна.

Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд батлагдсан XIII.1.1.275 хуулийн дугаартай 2022-2024 онд хэрэгжүүлэх 7,534.8 сая төгрөгийн өртөгтэй Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Завхан сум/ гэсэн төсөл арга хэмжээг баталсан байна.

Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 84 дүгээр албан бичгээр ирүүлсэн судалгаанаас харахад Завхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр 320 хүүхдийн хүчин чадалтай бөгөөд 310 хүүхэд суралцаж байна. Судалгаанаас харахад хичээлийн байрны хүчин чадал нь хүрдэггүй, суралцагч хүүхэд ихтэй сумдын Ерөнхий боловсролын сургуулиуд байна. Тухайлбал: Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр 320 хүүхдийн хүчин чадалтай бөгөөд 596 хүүхэд суралцаж байна.

Аудитын явцад Завхан суманд ажиллаж Ерөнхий боловсролын сургуулийн удирдлагатай ярилцлага хийж тайлбар авахад хичээлийн байр нь 1977 онд ашиглалтад орсон 45 жилийн насжилттай 320 хүүхдийн хүчин чадалтай, спорт заал нь агааржуулалт байхгүй, ариун цэврийн байгууламж нь гадна байрладаг, халаалтын систем нь анх барилга ашиглалтад орсон хэвээрээ байгаа, хүйтний улиралд доголдол их гардаг, өрөө танхим 10 градустай байдаг, цайны газар, урлаг

заал байхгүй, нийт 32 өрөөний 15 өрөөнд цууралт үүссэн хүндрэлтэй асуудлуудыг аймаг, суманд хандаж байсан гэж байна.

Зүүнговь суманд ажиллаж Ерөнхий боловсролын сургуулийн удирдлагатай ярилцлага хийж тайлбар авахад хичээлийн байр нь 1940 онд ашиглалтад орсон 320 хүүхдийн хүчин чадалтай, уг хичээлийн байр нь 1996 онд шатсан бөгөөд 2008 онд хичээлийн байранд их засвар хийсэн боловч хана таазаар дулаан алдалт ихтэй, анги танхимын хүрэлцээ муугаас багш нар сургалтаа явуулах, суралцагчид бусад сум сургуулийн суралцагчидтай ижил түвшинд сурч боловсрох, хүмүүжих нөхцөл боломжоор хангагдахгүй байгаа. Хичээлийн байр сургалт явуулах 10 танхимтай боловч өнөөдрийн байдлаар 24 бүлгийн 611 сурагч суралцаж байгаа нь 3 ээлжээр хичээллэх хэмжээнд хүрсэн тул Хүүхдийн цэцэрлэгийн хуучин байрыг ашиглан 8 бүлгийн 200 гаруй хүүхэд хичээллэж байна. Сумын нийт хүн амын тооноос харахад цаашид хичээлд элсэн орох хүүхдийн тоо жил бүр нэмэгдэж байгаа төдийгүй хичээлийн байрны хүрэлцээгүй байдлаас үүдэн 98 сурагч ойролцоох сумын болон аймгийн төвийн сургуульд элсэн суралцаж байна гэжээ.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээг аймаг орон нутгийн нөхцөл байдал суурь судалгаанд үндэслэн төлөвлөх шаардлагатай байгааг харуулж байна.

А.3.2. Шинээр хэрэгжүүлэх зураг төсөв боловсруулах шаардлагатай 19 төсөл, арга хэмжээнээс 2 ажлын зураг төсвийг хууль батлагдахаас өмнө, 17 ажлын зураг төсвийг хууль батлагдсаны дараа боловсруулж, баталгаажуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 30 төсөл, арга хэмжээнээс зураг төсөв хийгдэх шаардлагатай 19 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс 2 ажлын зураг төсөв хууль батлагдахаас өмнө хийгдсэн байна. Үүнд:

- Эрүүл мэндийн төвийн барилга /Увс, Тэс сум, Хар үзүүр, Таван улиас баг/
- Япон Улсын "Өвсний үндэс" хөтөлбөрийн үлдэгдэл санхүүжилт-сургуулийн урлаг, дизайны заалны өргөтгөл /Увс, Улаангом сум, 4 дүгээр сургууль/

Бусад 17 ажлын зураг төсөв Монгол улсын 2021 оны төсвийн тухай хууль батлагдсаны дараа боловсруулагдсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт "Засгийн газар барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 32.1.11 дэх хэсэгт "Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Цаашид Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ТЭЗҮ, зураг төсөв хийгдсэн ажлыг төлөвлөн батлуулж байхыг Үндэсний аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлэв.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд “Хөрөнгө оруулалтын төсөвлөлт”, 29.3 дахь хэсэгт “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана”;

- 29.3.1-д дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтаах;
- 29.3.2-д улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацаа, төсвийн жилд зарцуулах хэмжээгээр тусгах;
- 29.3.3-д нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах;
- 29.3.4-д санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;
- 29.3.5-д шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах гэж заажээ.

Аймгийн ТЕЗ-аас Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлэхдээ төсөвлөлтийн шаардлагыг хангаж цахим системээр болон албан бичгээр харьяа яамдад хүргүүлсэн байна.

А.3.3. Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжих зардлыг батлуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6 дахь заалтад “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэж заажээ.

Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуулиар Увс аймагт хэрэгжүүлэхээр баталсан 48 төсөл, арга хэмжээнд 2019-2021 онд хэрэгжүүлэх 1 төсөл, арга хэмжээ, 2019-2022 онд хэрэгжүүлэх 3 төсөл, арга хэмжээ, 2020-2021 онд хэрэгжүүлэх 13 төсөл, арга хэмжээ, 2020-2022 онд хэрэгжүүлэх 1 төсөл, арга хэмжээ, 2021 онд хэрэгжүүлэх 16 төсөл, арга хэмжээ, 2021-2022 онд хэрэгжүүлэх 12 төсөл, арга хэмжээ, 2021-2023 онд хэрэгжүүлэх 2 төсөл, арга хэмжээг тусгаж хугацаандаа хэрэгжих боломжтойгоор санхүүжилтийг баталсан байна.

А.3.4. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 3 төсөл, арга хэмжээг баталсан байна.

Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуулиар Увс аймагт хэрэгжүүлэхээр баталсан 48 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжуудаас Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалтад “Хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих

хөрөнгийн зарлагыг хэлнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна” гэж заасантай дараах 3 төсөл, арга хэмжээ нийцэхгүй байна. Үүнд:

- Сумын төвийн тохижилт /Увс, Улаангом сум/, 7,800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2021-2023 онд хэрэгжүүлэх, /Энэ ажлын хүрээнд 2021 онд 1600.0 сая төгрөгөөр Улаангом сумын 11 багийн зам дагуу айл, өрхийн хашааны нүүрэн хэсэг, хаалга солих, хогийн сав, шуудангийн хайрцаг байрлуулах, хаягжуулалт хийх ажлыг эхлүүлсэн байна/
- Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын гадна фасад, дулаалгын засвар /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/, 1,330.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2020-2021 онд хэрэгжүүлэх, /Энэ ажлын хүрээнд 2021 онд 930.0 сая төгрөгөөр Улаангом сумын 3 дугаар багийн зарим орон сууцны гадна фасад шинэчлэн хийжээ/
- Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дээврийн засвар /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/, 830.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2020-2021 онд хэрэгжүүлэх. /Энэ ажлын хүрээнд 2021 онд 530.0 сая төгрөгөөр Улаангом сумын 3 дугаар багт байрлах зарим орон сууцны гадна дээврийг шинэчлэн хийсэн байна/



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээг төлөвлөн, батлуулж байхыг УАГ-ын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлж байна.

БҮЛЭГ: 2. Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 7 төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, зарим тоног төхөөрөмжийг хэрэглэгчид бүрэн нийлүүлээгүй байна

Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж байгаа ч сонгон шалгаруулалттай холбоотой 2 худалдан авах ажиллагаанд оролцогч гомдол гарсныг Сангийн яамнаас үндэслэлтэй гэж үзжээ.

Б.1.1. Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий этгээд энэ хуулиар өөрт олгогдсон эрхийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж болох боловч ийнхүү эрхээ шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй”, Сангийн сайдын 2019 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” -ын 2.13-д “Захиалагч хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон тохиолдолд батлагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх” гэж заасан байна.

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг дараах байдлаар шилжүүлж болно”, 4.1.1-д “Төсвийн тухай хуулийн 14.4-д заасныг үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагчаас Төсвийн төвлөрүүлэн захирагчид, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг шилжүүлэх”, 4.1.2-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.6-д заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлэх” гэж заажээ.

Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Монгол улсын 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг баталсан байна.

Уг тогтоолоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд Увс аймагт шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 30 төсөл, арга хэмжээнээс 10 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 10 төсөл, арга хэмжээг салбар яамны сайдын багцаар авч үзвэл. Үүнд:

- Эрүүл мэндийн сайдын 2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн төвийн барилга /Увс, Тэс сум, Хар үзүүр, Таван улиас

- баг/ 200.0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, төсвийг зарцуулах эрхийг,
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/678 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар Жуулчдад мэдээлэл өгөх цэг, отоглох талбай байгуулах /Увс, Малчин, Завхан, Наранбулаг, Хяргас, Цагаанхайрхан/ 500.0 сая, Усны нөөц усжуулалтын чанарын техник, эдийн засгийн үндэслэл /Увс/ 200.0 сая, нийт 700.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, төсвийг зарцуулах эрхийг,
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/33 дугаар тушаалын хавсралтаар “Шинэ хөдөө” төсөл /Увс/, 650.0 сая, Баруун бүсийн логистик төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом сум/ 250.0 сая, Цагаан ултай гутлын кластер төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс/ 100.0 сая, Гурил, тэжээлийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв /Увс, Улаангом, Баруунтуруун сум/ 200.0 сая, нийт 1,200.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, төсвийг зарцуулах эрхийг,
 - Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 34 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар Нийтийн халуун усны барилгын их засвар /Увс, Бөхмөрөн сум/ 50.0 сая, Хог тээврийн авто машин /Увс, Бөхмөрөн сум/ 30.0 сая, Бизнес инкубатор төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв /Увс, Улаангом сум/ 100.0 сая, нийт 180.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, төсвийг зарцуулах эрхийг шилжүүлсэн байна.

Дээрх Төсөл, арга хэмжээнүүдийн эрхийг хэрэгжих боломжтой хугацаанд шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн 10 төсөл, арга хэмжээнээс сумдад болон төсөвт байгууллагад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Б.1.2. Төсөл, арга хэмжээний зураг төсөв, техникийн тодорхойлолт батлагдаж гараагүй, зарим төсөл, арга хэмжээнд оролцогч ирээгүй, шаардлага хангахгүй зэрэг шалтгаанаар худалдан авах ажиллагаа оройтож явагдсанаас хугацаа алджээ.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2021 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх эрх шилжиж ирсэн 10 төсөл, арга хэмжээнээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно” гэж заасны дагуу 1 төсөл, арга хэмжээг 5 багц, 1 төсөл, арга хэмжээг 4 багц болгон, нийт 17 худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Төсөл, арга хэмжээний зураг төсөв, техникийн тодорхойлолт батлагдахгүй хугацаа алдсанаас худалдан авах ажиллагаа оройтож зарлагдсан байна. Үүнд:

- Үнэлгээний хороо байгуулахаар төлөвлөсөн хугацааг нийт 9 төсөл, арга хэмжээнд 30-84 хоногоор хэтрүүлэн байгуулсан.
- Тендер зарлах хугацааг нийт 10 төсөл, арга хэмжээнд 31-140 хоногоор хэтрүүлэн зарласан байна.

- Гэрээ байгуулах эрх олгох хугацааг нийт 17 худалдан авах ажиллагаанд 24-153 хоногоор хэтрүүлэн байгуулсан байна.

Зарим төсөл, арга хэмжээнд оролцогч материал ирүүлээгүй учраас 2-4 удаа тендер зарлаж хугацаа алдсан байна. Үүнд:

- Баруун бүсийн логистик төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн /Увс, Улаангом сум/ 250.0 сая төгрөгийн ажилд 2 удаа
- Гурил, тэжээлийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн /Увс, Улаангом, Баруунтуруун сум/ 200.0 сая төгрөгийн ажилд 2 удаа
- Нийтийн халуун усны барилгын их засварын /Увс, Бөхмөрөн сум/ 50.0 сая төгрөгийн ажилд 4 удаа
- Бизнес инкубатор төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн 100.0 сая төгрөгийн ажилд 2 удаа
- Шинэ Хөдөө /Увс/ 4 багц бүхий 650.0 сая төгрөгийн ажилд 2 удаа

Б.1.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулж, батлуулж, хэрэгжүүлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн захирамжаар төсөл, арга хэмжээ бүрд үнэлгээний хороог томилсон байна. Мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна” гэж заасныг хэрэгжүүлэн ажилласан байна.

Үнэлгээний хороонд аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, тухайн салбарын холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Захиалагч тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэнэ”, 19.2 дахь хэсэгт “Тендерийн баримт бичигт тендер оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендер оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана” гэж заасны дагуу тендерийн бичиг баримтыг боловсруулжээ.

Б.1.4. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан ч, сонгон шалгаруулалттай холбоотой 2 гомдол гарсан нь үндэслэлтэй байжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Тендер оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн

ерөнхий, санхүүгийн, техникийн чадавх болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлна” гэж заажээ.

Худалдан авах ажиллагаа явуулах бүрд үнэлгээний хорооны гишүүд хууль, тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүсэн тухай мэдэгдлийн маягтыг урьдчилсан мэдүүлсэн байна.

Орон нутгийн өмчийн газар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт 2021 онд хэрэгжих эрх шилжиж ирсэн 10 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид 17 тендер худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулсан байна.

Ингэхдээ 11 төсөл, арга хэмжээнд нээлттэй тендер шалгаруулалт, 2 төсөл, арга хэмжээнд харьцуулалтын аргаар, 4 төсөл, арга хэмжээнд хосолмол үнийн аргаар худалдан авах ажиллагаа байгуулжээ.

Дээрх худалдан авах ажиллагаанаас нээлттэй тендер шалгаруулалтаар зарлагдсан Жуулчдад мэдээлэл өгөх цэг, отоглох талбай байгуулах төсөл, арга хэмжээний багц-1, багц-4 дугаартай ажилд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт “Тендерт оролцогч нь энэ хуулийн 11.2-т заасныг зөрчсөн болон тендерийн баримт бичиг бэлтгэх явцад өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэгэн зөрчил гарсан гэж үзвэл гомдлоо тендерийн нээлт хийхээс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт, захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, эсхүл гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг зөвхөн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ажлын 5 өдрийн дотор гаргана” гэж заасны дагуу тендерт оролцогч гомдол гаргасан байна.

Уг гомдлыг Сангийн яам хянан үзэж гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хүчингүй болгож тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийх мэдэгдлийг хүргүүлсний дагуу тендер худалдан авалтын үнэлгээг дахин хийж гүйцэтгэгчийг шинээр сонгон шалгаруулсан байна.

Орон нутгийн өмчийн газар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”, 21.2 дахь хэсэгт “Захиалагч тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, нээлттэй зарлах бөгөөд сонирхсон этгээдэд саадгүй олгоно” гэж заасны дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим сайтад байршуулж, тендерийн урилгыг tender.gov.mn, Увс Орон нутгийн өмчийн газар facebook хаяг, UVS.ONUG@G-mail цахим хаяг, MBC телевиз, Увс нам бус телевиз гэсэн орон нутгийн телевиз болон Өглөөний сониноор олон нийтэд мэдээлсэн байна. Мөн 70453262 утсаар иргэд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл өгч ажилласан байна.

Б.1.5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнаж, шилэн дансанд тавьж, нийтэд мэдээлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь заалтад “Тухайн жилд

худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана” гэж заасны дагуу Увс аймгийн Орон нутгийн өмчийн газраас Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны хагас жилийн тайланг 2021 оны эхний хагас жилийн тайланг 07 дугаар сарын 05-ны өдрийн 98 тоот албан бичгээр, 2021 оны худалдан авах ажиллагааны жилийн тайланг 2022 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр гарган Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Тайлант оны бүтэн жилийн тайланг Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 4.3-д “Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг эрх шилжүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана” гэж заасны дагуу цахим системд байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1 дэх хэсэгт “Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.6 дахь заалтад “Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн”, 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна”, 5.8 дахь хэсэгт “Мэдээллийн самбар нь олон нийт мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг хангасан, түүнд тавигдсан мэдээлэл нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байна” гэж заажээ.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хуулийн хугацаанд шилэн дансны мэдээллийн цахим сайтад байршуулжээ. Мөн мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд мэдээлсэн байна.

Б.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 7 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч захиалагчтай байгуулсан гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, зарим тоног төхөөрөмжийг хэрэглэгчид бүрэн нийлүүлээгүй, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй байна.

Б.2.1. Хөрөнгө оруулалтын 7 төсөл, арга хэмжээг гүйцэтгээгүй захиалагчтай байгуулсан гэрээний хугацаанд гүйцэтгээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт 2021 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 48 төсөл, арга хэмжээнээс 19 төсөл, арга хэмжээг захиалагчтай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгсөн, 18 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжихээр байна.

Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөл, төсвөөр захиалагчтай байгуулсан гэрээний дагуу үе шатны ажил болгон дээр хяналт хийж ил далд ажлын актаар баталгаажуулжээ.

Харин Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт 2021 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 48 төсөл, арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээ 2021 онд огт хийгдээгүй байна. Үүнд:

- Модон гүүр /Увс, Завхан сум, Хармагт баг/ -тус төсөл арга хэмжээ нь хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн холбогдох мэргэжилтэн, сумдын удирдлагууд, мэргэжлийн зураг төслийн байгууллагын инженерүүд газар дээр нь очиж гүүр тавих боломжтой цэгийг судлахад Завхан голын хамгийн богино хэсэг нь 250 м өргөн байгаа бөгөөд мэргэжлийн байгууллагууд нь 300.0 сая төгрөгөөр 250 у/м модон гүүрийг барих боломжгүй төсөл гэж үзсэн учир хэрэгжүүлээгүй.

Дараах 3 төсөл арга хэмжээний хувьд 2021 онд зураг төсөв хийгдэж, гүйцэтгэгч шалгаруулах тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт зарласан боловч 2021 онд багтаж гүйцэтгэгч шалгараагүй учир хэрэгжүүлээгүй байна.

- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Увс, Ховд сум/
- Ухаалаг худаг бүхий нийтийн халуун усны барилга /Увс, Зүүнхангай сум/
- Сумын төвийн тохижилт /Увс, Түргэн сум/

Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт 2021 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 48 төсөл, арга хэмжээнээс гэрээний дагуу 2021 онд дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөхөөр байсан 7 төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусаагүй байна. Үүнд:

- ❖ Усан бассейн, спорт фитнесийн барилга /Увс, Улаангом сум/-Гүйцэтгэгч ажлыг зогсоосон.
- ❖ Дотуур байрын барилга, 100 ор /Увс, Ховд сум/- Материал, тээврийн үнэ өссөн шалтгаанаар гүйцэтгэгч хүсэлт гаргасан.
- ❖ Эрүүл мэндийн төвийн барилга /Увс, Тэс сум, Хар үзүүр, Таван улиас баг/- Гүйцэтгэгч ажлаа хугацаандаа хийж гүйцэтгээгүй.
- ❖ Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Увс, Тэс сум/- Гүйцэтгэгч ажлаа хугацаандаа хийж гүйцэтгээгүй.
- ❖ Нийтийн эзэмшлийн орон сууцын байруудын дээврийн засвар /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/- Гүйцэтгэгч ажлаа хугацаандаа хийж гүйцэтгээгүй.

- ❖ Багийн тохижилт, гэрэлтүүлэг, камержуулалт /Увс, Улаангом сум, 9 дүгээр баг/- Гүйцэтгэгч ажлаа хугацаандаа хийж гүйцэтгээгүй.
- ❖ "Шинэ хөдөө" төсөл /Увс/- Гүйцэтгэгч ажлаа хугацаандаа хийж гүйцэтгээгүй.

Дээрх гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй төсөл, арга хэмжээнүүдийн ажлыг хийлгэж хүлээн авахыг зөвлөмж болгов.

Жуулчдад мэдээлэл өгөх цэг, отоглох талбай байгуулах /Увс, Малчин, Завхан, Наранбулаг, Хяргас, Цагаанхайрхан сум/ 500.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээнд 5 багц тендер зарлаж гүйцэтгүүлсэн ажлуудад аймгийн Засаг даргын 2021 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн А/478 дугаар захирамжаар “Отоглох цэгийн үйл ажиллагааг хариуцан ажиллуулах түр журам” баталсан байна. Журмын хүрээнд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хан хөхийн нурууны улсын тусгай хамгаалалтын захиргаа, хариуцагчтай гуравласан гэрээг зарим отголох цэгт байгуулжээ. Гэрээний дагуу хариуцагч отголох цэгийн хөрөнгийг хүлээн авахаар очиход зарим зүйлийг хулгай авсан, эвдэрсэн байдалтай байсан байна. Үүнд:

1. Наранбулаг сумын нутагт байрлах отголох цэгт гадна гэрэлтүүлгийн толгой 2 ширхэг алга болсон, гадна хашааны олс 70 метр алга болсныг эд хөрөнгө хүлээлгэн өгсөн жагсаалтад тухайн ажлын гүйцэтгэгч аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэхээр болсон.
2. Хан Хөхий нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаанд Малчин, Завхан, Хяргас, Цагаанхайрхан гэсэн 4 суманд байрлах отголох цэгийн түлхүүрийг гүйцэтгэгчээс түр хүлээлгэн өгсөн байх бөгөөд хариуцан ажиллуулахаар сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдэд хүлээлгэн өгөхөөр очиход Малчин, Хяргас сумын нутагт байрлах отголох цэгийн зарим эд зүйлийг тонож хулгай авсан байсныг Увс аймгийн Цагдаагийн газарт шалгуулахаар шилжүүлсэн байна.

Б.2.2. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналт үр дүнтэй хэрэгжсэн байна.

Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу үе шат бүр дээр хэрэгжүүлэн ажилласан байна. Ингэхдээ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөл, захиалагчийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу ил далд ажлын актаар баталгаажуулж, гэрээний хугацаанд гүйцэтгүүлэх талаар зөвлөмж чиглэл өгсөн байна. Мөн гүйцэтгэл нь дууссан төсөл, арга хэмжээ бүрд улсын комисс ажиллуулах Засаг даргын захирамж гарч ашиглалтад хүлээн авсан байна.

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 15.3 дахь заалт болон Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.3 дахь заалтад “Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрд зохиогчоор

хяналт тавиулж, дүгнэлт гаргуулна” гэж заасны дагуу зохиогчийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулсан байна.

Б.2.3. Хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн зарим тоног төхөөрөмжийг хэрэглэгчид бүрэн нийлүүлээгүй, хүлээлгэн өгөөгүй байна.

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн техник хэрэгсэл нийлүүлэх 6 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- ✚ Аймгийн Цагдаагийн газрын авто парк шинэчлэл /Увс, Улаангом/ 2021-2022 онд хэрэгжих 160.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээ 2021 онд 80.0 сая,
- ✚ Хог тээврийн автомашин /Увс, Бөхмөрөн сум/ 2021 онд хэрэгжих 30.0 сая төгрөг,
- ✚ Сумын хэрэгцээнд универсал трактор /Увс, Цагаанхайрхан сум/ 2021 онд хэрэгжих 120.0 сая,
- ✚ Сумын хэрэгцээнд универсал трактор /Увс, Өндөрхангай сум/ 2021 онд хэрэгжих 120.0 сая,
- ✚ Сумын хэрэгцээнд универсал трактор /Увс, Зүүнхангай сум/ 2021 онд хэрэгжих 120.0 сая,
- ✚ Сургуулийн дунд оврын автобус /Увс, Өлгий сум/ 2021 онд хэрэгжих 50.0 сая төгрөг.

Дээрх хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн техник, хэрэгслийг хууль, эрх зүйн баримт бичигт туссан үзүүлэлт, хэмжээгээр бүрэн нийлүүлсэн байна.

Харин Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуулиар баталсан XVII.3.5 хуулийн дугаартай 2021-2023 онд хэрэгжүүлэх нийт 4,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шинэ хөдөө” төслийн 2021 онд санхүүжүүлэх 650.0 сая төгрөгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн 3 ажлын зарим тоног төхөөрөмж ирээгүй, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй байна. Үүнд:

- Сүү, цагаан идээ боловсруулах цех байгуулах /Өндөрхангай, Улаангом/ гэсэн 440.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний цехийн барилгыг барьсан боловч тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй байна. Тодруулахад Ковид-19 цар тахлын улмаас хил хаасантай холбоотойгоор нийлүүлэгдээгүй байгаа гэсэн тайлбар өгсөн.
- Мөн төслийн хүрээнд хийгдсэн Жижиг оврын тэжээл боловсруулах цехийн тоног төхөөрөмж 160.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж тоног төхөөрөмж нийлүүлэгдэж ирсэн боловч ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй аймгийн ЗДТГ-ын аж ахуйн хашаанд хадгалагдаж байна,
- Ашиглалтын зардал багатай, эрчим хүч, шатахуун зарцуулдаггүй, хэмнэлттэй, инновацын шийдэлтэй, голоос тариалангийн талбай руу ус шахах төхөөрөмж худалдан авах 50.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж ирсэн боловч хэрэглэгчдэд хүлээлгэн өгөөгүй аймгийн ЗДТГ-ын аж ахуйн хашаанд хадгалагдаж байна.



Дээрх нийлүүлэгдээгүй байгаа тоног төхөөрөмжийг гэрээний дагуу гүйцэтгэгчээс бүрэн хүлээн авах, ирсэн тоног төхөөрөмжийг ашиглагч

байгууллагад хүлээлгэн өгөхийг зөвлөмж болгов.

Б.2.4. Өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон 1 барилга, байгууламж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2011-2013 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Боршоо” олон улсын худалдааны төвийн барилга угсралтын ажил нь 271.6 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон 30 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжиж дуусаагүй үлдэгдэл санхүүжилт батлагдаж ирээгүй шалтгаанаар орхигдсон байна. Уг ажилтай холбоотой мэдээллийг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 148 дугаар албан бичгээр ҮАГ-ын гүйцэтгэлийн аудитын газарт хүргүүлж байсан болно.

Мөн 2019 оноос дамжин хэрэгжиж байгаа Улсын төсвийн 2021 оны төсөвт батлагдсан дараах 2 төсөл, арга хэмжээний хүрээнд 2021 онд ямар нэгэн ажил хийгдээгүй, санхүүжилтийг олгоогүй байна. Үүнд:

- ❖ Усан бассейн, спорт фитнесийн барилга /Увс, Улаангом сум/ 2019-2021 онд хэрэгжүүлэх 4,100.0 сая төгрөгийн төсөвтэй, 2021 онд 500.0 сая төгрөг тусгагдсан. Уг ажил 2019 онд гэрээ байгуулагдаж БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “ЗУНБОО” ХХК шалгарч гэрээ байгуулан 2019, 2020 онд гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг авсан байна. Харин 2021 онд гүйцэтгэгч компанийн эзэмшигч тодорхойгүй нөхцөл байдал үүссэний улмаас ажил нь зогссон байна.
- ❖ Оюутны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/ 6,369.8 сая төгрөгийн төсөвтэй, 2021 онд 500.0 сая төгрөг тусгагдсан. Уг ажил нь барилгын төсөв зохиох программаар 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс цалингийн зардлыг өсгөж боддог болсонтой холбоотойгоор 2021 оны Улсын төсөвт 6,369.8 сая төгрөг болгон баталсан байна. Уг ажлын нэмэгдсэн төсөв нь магадлалаар баталгаажаагүй учир аймгийн ТЭЗ-ийн зүгээс гэрээнд өөрчлөлт оруулаагүй байх бөгөөд 2021 онд үйл ажиллагаа явуулаагүй байна.



Б.2.5. Хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн ТЭЗҮ-ийг мөрдөгдөж байгаа хууль, барилгын норм, дүрэм, стандартын дагуу боловсруулж, 2021 онд хэрэгжүүлсэн, 2022 онд хэрэгжүүлэх 2 барилга байгууламжийн ТАХ-нд ашигласан байна.

Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуульд тусгагдсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах дараах 5 төсөл арга хэмжээг хийж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ✓ Усны нөөц, усжуулалтын чанарын техник, эдийн засгийн үндэслэл /Увс/ 200.0 сая,
- ✓ Бизнес инкубатор төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом сум/ 100 сая,
- ✓ Баруун бүсийн логистик төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом сум/ 250.0 сая,
- ✓ Цагаан ултай гутлын кластер төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс/ 100 сая,
- ✓ Гурил, тэжээлийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом, Баруунтуруун сум/ 200.0 сая

Дээрх 5 техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах ажлаас Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд 2 төсөл, арга хэмжээ тусгагдан батлагдсан байна. Үүнд:

- ✓ Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/ 1,800.0 сая,
- ✓ Цагаан ултай гутлын кластер төвийн барилга /Увс/ 2,880.0 сая

Б.3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг хэрэгжүүлж байгаа ч үе шатны ажил бүр дээр нарийн мэргэжлийн мэргэжилтнийг оролцуулан хяналт хийдэггүй, зохиогчийн хяналтын гэрээг ТЕЗ-тай байгуулаагүй байна.

Б.3.1. ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн үе шатны хяналтыг тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлсэн ч үе шатны ажил бүр дээр нарийн мэргэжлийн мэргэжилтнийг оролцуулан хяналт хийдэггүй, зохиогчийн хяналтын гэрээг ТЕЗ-тай байгуулаагүй байна.

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 35.1.1 дэх хэсэгт “нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих”, 35.1.4 дэх хэсэгт “тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах”, 35.1.6 дахь заалтад “барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах”, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ, 37.1.4 дэх заалтад “барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах”, 37.1.9 дэх заалтад “барилгын үйл ажиллагаанд холбогдох барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг баримтлан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж холбогдох зардлыг хариуцах” гэж заажээ.

Мөн Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 15.1 дэх хэсэгт болон Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.1-д “Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгүүлж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм,

стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ”, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 15.2 дахь заалт болон Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.2 дахь заалтад “Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4.1.4-д заасан нөхцөл байдал илэрсэн бол холбогдох мэдээллийг эрх бүхий улсын байцаагчид хүргүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр авч ажиллана” гэж заасан байна.

Барилга хөгжлийн төвийн захирал аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргатай 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 2021/43 дугаар “Аймагт хэрэгжүүлсэн барилга, байгууламжийн ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээ”-г байгуулан ажилласан байна.

Мөн аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргатай 2021 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 01/2021 дүгээр “Аймагт хэрэгжүүлсэн барилга, байгууламжийн ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээ”-г байгуулан ажилласан байна.

Гэрээний 1.4-д “Энэхүү гэрээ нь 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ” гэж заажээ. Цаашид гэрээг тайлант хугацааны эхэнд байгуулж байхыг зөвлөмж болгож байна.

Уг гэрээнд заасны дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг үе шатны ажил болгон дээр хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зөвлөмж, чиглэл өгч ажиллаж байгаа ч үе шатны ажил бүрд хяналт хийх баг бүрдүүлж ажиллахгүй байна. Өөрөөр хэлбэл тухайлсан төсөл, арга хэмжээний үе шат болгон дээрх хяналтыг нэг мэргэжилтэн хийж байна.

Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдэд аймгийн Засаг даргын улсын комисс ажиллуулах захирамж гарч ашиглалтад хүлээн авсан байна.

Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ, 37.1.5 дахь заалтад “барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Зураг төсөл зохиогч дараах чиг үүрэгтэй”, 38.1.3 дахь заалтад “зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх, 38.1.4 дэх заалтад “зохиогчийн техникийн хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн

дээр гүйцэтгэх” 38.1.8 дахь заалтад “барилгын ажилд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авахыг захиалагчаас шаардах, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.1-д “Зураг төсөл зохиогч барилгын ажлын захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина”, 3.3-д “Зохиогчийн хяналт гүйцэтгэх хэлбэрийг зураг төсөл зохиогч, захиалагч, барилгын ажил гүйцэтгэгч тохиролцож гэрээгээр зохицуулна” гэж заасан байна.

Зохиогчийн хяналтыг зураг төсөв боловсруулсан байгууллага хийхдээ аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газартай гэрээ байгуулан гүйцэтгэж байна.

Цаашид “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.1-д “Зураг төсөл зохиогч барилгын ажлын захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина” гэж заасны дагуу захиалагч болох аймгийн Засаг дарга зураг төсөв боловсруулсан байгууллагатай гэрээ байгуулан зохиогчийн хяналтыг хийлгэж байхыг зөвлөмж болгов.

Б.3.2. Эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.6 дахь заалтад “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэж заажээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн эрх шилжиж ирсэн 24 төсөл, арга хэмжээнээс 12 төсөл, арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээн авч санхүүжилтийг гэрээнд заасан хугацаанд бүрэн олгосон байна.

Дараах 10 төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэлд ногдох санхүүжилтийг олгосон байна.

- ❖ Спорт цогцолборын барилга /Увс, Тариалан сум/-гүйцэтгэлийн хувь 82
- ❖ Нийтийн эзэмшлийн орон сууцын байруудын дээврийн засвар /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/- гүйцэтгэлийн хувь 88
- ❖ Бизнес инкубатор төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом сум/- гүйцэтгэлийн хувь 39
- ❖ Дотуур байрын барилга, 100 ор /Увс, Ховд сум/- гүйцэтгэлийн хувь 88
- ❖ Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Увс, Тэс сум/- гүйцэтгэлийн хувь 89
- ❖ Аймгийн хөгжимт драмын “Ойрад” театрын барилга /Увс, Улаангом сум/- гүйцэтгэлийн хувь 92
- ❖ Сүү Цагаан Идээ боловсруулах Цех байгуулах /Улаангом, Өндөрхангай сум/- гүйцэтгэлийн хувь 63
- ❖ Баруун бүсийн логистик төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом сум/- гүйцэтгэлийн хувь 85
- ❖ Гурил, тэжээлийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом, Баруунтуруун сум/ - гүйцэтгэлийн хувь 79.9
- ❖ Эрүүл мэндийн төвийн барилга /Увс, Тэс сум, Хар үзүүр, Таван улиас баг/ - гүйцэтгэлийн хувь 89

Харин 2021 онд ямар нэгэн ажил хийгдээгүй 2 төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгоогүй аймгийн ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна. Үүнд:

- ❖ Усан бассейн, спорт фитнесийн барилга /Увс, Улаангом сум/
- ❖ Оюунтны дотуур байрны барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/ 6369.8 сая төгрөгийн төсөвтэй, 2021 онд 500.0 сая төгрөг тусгагдсан.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, тайлагналын журмын 6.3, 6.4 дэх заалтын дагуу эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн тайлан, ашиглалтад орсон барилга, байгууламжийн мэдээг тухай бүр гаргаж хүргүүлсэн байна.

Б.3.3. Хөрөнгө оруулалтын үйл явцад ТЕЗ-ын дотоод хяналтыг 2 удаа хэрэгжүүлсэн байна.

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 35.1.3 дахь заалтад “барилга байгууламжийн байршил тогтоох, газар олголт, загвар зураг батлах болон техникийн нөхцөл олгох үйл ажиллагааг зохион байгуулж, нэгдсэн бүртгэл хөтлөх, хадгалах, мэдээлэл түүний аюулгүй байдлыг хангах, мэдээллийн сангийн байнгын үйл ажиллагааг эрхлэх, хяналт тавих”, 35.1.4 дэх заалтад “тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах”, 35.1.7 дахь заалтад “барилга байгууламжийн баримт бичгийн шаардлагад нийцээгүй барилга байгууламжийг улсын хяналт хэрэгжүүлэгч байгууллагын ерөнхий байцаагчийн дүгнэлт болон шүүхийн шийдвэрийг үндэслэн албадан буулгах арга хэмжээг авч, холбогдох зардлыг буруутай этгээдээр төлүүлэх”, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.4 дэх заалтад “барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах”, 37.1.5 дахь заалтад “барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах” гэж заажээ.

Аймгийн ИТХ-ын тогтоол гарч ажлын хэсэг байгуулагдан, уг ажлын хэсэгт аймгийн Засаг даргын зөвлөлийн төлөөлөл болон ажлын албаны мэргэжилтэн нар орж 2021 онд 2 удаа Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим төсөл, арга хэмжээнд үйл явцын хяналт хийж, ажлын гүйцэтгэлтэй газар дээр нь танилцсан байна.

Харин аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хөрөнгө оруулалтын ажлын үйл явцад хяналт хийгээгүй байна.

Б.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалт тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гарсан шийдвэр үр дүнтэй байна.

Б.4.1. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд 10 төсөл, арга хэмжээний 1,900.5 сая төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлжээ.

Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 397 дугаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.2-д “Коронавирус халдвар /Ковид-19/ -ын цар тахлын нөлөөллөөс үүдэн улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр батлагдаж гэрээ нь байгуулагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/823 дугаар “Барьцаа дансанд байршуулах тухай” захирамж гаргасан байна.

Уг захирамжийн хавсралтаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй өмнөх оноос шилжин хэрэгжиж байгаа 4, 2021 онд шинээр хэрэгжүүлж байгаа 6, нийт 10 төсөл, арга хэмжээний 1,900.5 сая төгрөгийг аймгийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна. Үүнд:

/сая. төгрөгөөр/			
Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Байршуулах дүн	Данс
1	Эрүүл мэндийн төвийн барилга /Увс, Тэс сум, Хар үзүүр, Таван улиас баг/	21.5	100150020300
2	Сүү, цагаан идээ боловсруулах цех байгуулах /Улаангом сум/	80.5	100150020300
3	Сүү, цагаан идээ боловсруулах цех байгуулах /Өндөрхангай сум/	80.2	100150020300
4	Баруун бүсийн логистик төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом сум/	37.3	100150020300
5	Бизнес инкубатор төвийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом сум/	59.7	100150020300
6	Гурил, тэжээлийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Увс, Улаангом, Баруунтуруун сум/	39.3	100150020300
7	Дотуур байрын барилга, 100 ор /Увс, Ховд сум/	151.9	100150020300
8	Оюутны дотуур байрын барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/	500.0	100150020300
9	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Увс, Тэс сум/	430.1	100150020300
10	Усан бассейн, спорт фитнесийн барилга /Увс, Улаангом сум/	500.0	100150020300
	Нийт	1,900.5	

/аймгийн Засаг даргын захирамж, барьцаа хөрөнгийн дансны хуулга/

Б.4.2. 2020 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан 12 төсөл, арга хэмжээний 1,433.9 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлснийг бүрэн олгожээ.

Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 253 дугаар тогтоолын 1.2 дахь хэсэгт “Монгол Улсад короновируст халдвар /КОВИД-19/-ын

цар тахлын тохиолдол бүртгэгдэж бүх нийтийн бэлэн байдал болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээс шалтгаалан эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж байгаа 2020 онд хэрэгжиж дуусах боловч батлагдсан санхүүжилтийг бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн, мөн бусад салбарын зайлшгүй шаардлагатай болон Засгийн газрын 2019 оны 280 дугаар тогтоолын хүрээнд хийгдэж байгаа бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний 2020 оны үлдэгдэл санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах” гэж заасны дагуу 12 төсөл, арга хэмжээний нийт 1,433.9 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

Аймгийн барьцаа хөрөнгийн дансанд өмнөх онд төвлөрүүлсэн 1,433.9 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хангуулан санхүүжилтийг бүрэн олгосон байна. Үүнд:

- Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн цахим номын сантай болгох ажилд 34.5 сая
- Улаангом сумын 4,9,10,11 дүгээр багийн төвийн тохижилтын ажилд 147.2 сая
- Зүүнговь сумын сургуулийн спорт заалны барилгын ажилд 145.8 сая
- Улаангом сумын 1,2,5,6 дугаар багийн төвийн тохижилтын ажилд 323.5 сая
- Аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгын их засварын ажилд 153.0 сая
- 50 ортой Хүүхдийн эмнэлгийн барилгын ажилд 229.7 сая
- Аймгийн нэгдсэн эмнэлгийн цахилгаан шатны ажилд 47.9 сая
- Зүүнговь сумын Эрүүл мэндийн төвийн засварын ажилд 39.7 сая
- Зүүнговь сумын Хүүхдийн Цэцэрлэгийн барилгын ажилд 123.7 сая
- Улаангом сумын 2 дугаар багийн гэр хорооллын гудамжны зам сайжруулах ажилд 31.4 сая
- Тэс сумын тохижилтын ажилд 111.6 сая
- Улаангом сумын 2 дугаар багт мал угаалгын ванн, гүний худаг гаргах ажилд 45.9 сая

Б.4.3. 2021 онд байнгын ашиглалтад орсон зарим барилга байгууламж, Төрийн өмчийн хорооны шийдвэр ирээгүйгээс данс бүртгэлд тусгаагүй, барилга байгууламж, зарим техник тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолын дагуу аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн тогтоол гарч 2019, 2020, 2021 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг Төрийн өмчийн хорооны болон аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн данс бүртгэлд тусгасан байна. Үүнд:

- ✚ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 19 дүгээр тогтоолын дагуу нийт 4,646.9 сая төгрөгийн 2019 оны 2, 2020 оны 2, нийт 4 төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/24 дүгээр тогтоолоор,
- ✚ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 84 дүгээр тогтоолын дагуу нийт 11,750.6 сая төгрөгийн 2020 оны 9, 2021 оны 1, нийт 10 төсөл, арга хэмжээ болон засварын 6 төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн А/74 дүгээр тогтоолоор,
- ✚ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 396 дугаар тогтоолын дагуу нийт 5361.1 сая төгрөгийн 2020 оны 3 төсөл,

арга хэмжээ болон тохижилтын 1 төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/161 дүгээр тогтоолоор, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 544 дүгээр тогтоолын дагуу 2, 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын дагуу 5, нийт 8072.8 сая төгрөгийн 2018 оны 1, 2020 оны 3, 2021 оны 3, нийт 7 төсөл, арга хэмжээг, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/159 дүгээр тогтоолоор, Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/158 дугаар тогтоолоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн нийт 5,071.2 сая төгрөгийн 14 барилгын өргөтгөл, их засварын ажлыг тус тус данс бүртгэлд тусгасан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол гарсан ч үнийн дүн зөрүүтэй байгаагаас шалтгаалан 2 төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй буцаан албан тоот хүргүүлжээ. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор Цэцэрлэгийн барилга, 240 ор /Увс, Тариалан сум/
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 487 дугаар тогтоолоор Цогцолбор барилга /Увс аймаг, Өлгий сум/

Төрийн өмчийн хорооны шийдвэр ирээгүйгээс зарим хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

- Жуулчдад мэдээлэл өгөх цэг, отоглох талбай байгуулах /Увс, Малчин, Завхан, Наранбулаг, Хяргас, Цагаанхайрхан сум/
- Наадмын талбайн тохижилт /Увс, Улаангом сум/
- Харилцаа холбооны дахин дамжуулах станц /Увс, Өмнөговь сум, Улиаст баг/
- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Увс, Улаангом сум, 3 дугаар баг, 5 дугаар цэцэрлэг/
- 0.4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл /Увс, Улаангом сум, 12 дугаар баг/

Харин Сумын хэрэгцээнд универсал трактор /Увс, Цагаанхайрхан сум/ гэсэн төсөл, арга хэмжээг Төрийн өмчийн хорооны шийдвэргүйгээр гэрээний дүнгээр 116.1 сая төгрөгөөр данс бүртгэлд тусгасан байна. Цаашид аймгийн Орон нутгийн өмчийн газраас бодлого арга зүйгээр хангаж ажиллах нь зүйтэй.

Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 2021 онд аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Зооноз өвчин судлалын төв, 18 сумын ЭМТ болон аймгийн төвийн 4 өрхийн эмнэлэгт нийт 3,071.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээр 2 барилгын засвар, өргөтгөлийн ажил, 225 нэр төрлийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл ирүүлснийг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Салбар яам, ерөнхий газраас ирүүлсэн хөрөнгийн судалгаа мэдээлэл аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирдэггүй, харилцаа хамтын ажиллагаа муу байгаагаас шалтгаалан Боловсрол, Эрүүл мэндийн салбарын төсөвт байгууллагуудад тайлант онд ямар хөрөнгө ирсэн, данс бүртгэлд үнэн зөв тусгасан эсэх нь тодорхойгүй, байгууллагын өмчийн тайланд тусгагдахгүй он дамжих эрсдэл үүсгэж байна. Тухайлбал:

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 2021 онд Увс аймгийн сумдын 10 Ерөнхий боловсролын сургууль, 9 Цэцэрлэг, нийт 19 байгууллагад 317.1 сая төгрөгийн 614 нэр төрлийн тоног төхөөрөмж, тавилга, хэрэгсэл, аж ахуйн материал

ирүүлсэн байна. Аудитын явцад зарим сумдаар ажиллаж уг хөрөнгө, материалд тооллого хийж тулган баталгаажуулахад 4 сумын 8 цэцэрлэгт 3 нэр төрлийн 127 ширхэг 20.2 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг бэлтгэн нийлүүлэгч “Долоон болдог” ХХК бэлтгэн нийлүүлээгүй байна. Үүнд:

- ✚ Вандан сандал 28 ширхэг 1.6 сая,
- ✚ Сургалтын хэрэглэгдэхүүний шүүгээ 22 ширхэг 2.5 сая,
- ✚ Хүүхдийн хувцасны шүүгээ 77 ширхэг 16.4 сая төгрөг байна.

Дээрх тавилга, эд хогшлыг “Долоон болдог” ХХК-аар бэлтгүүлэн Улаангом сумын 2,3,5,6,7 дугаар, Баруунтуруун, Зүүнговь, Малчин сумдын Хүүхдийн цэцэрлэгүүдэд хүлээлгэн өгч, данс бүртгэлд тусгуулахыг зөвлөмж болгов.

Цаашид салбар яам болон аймгийн хэлтэс, агентлаг, Орон нутгийн өмчийн газрын харилцаа хамтын ажиллагааг сайжруулах талаар Үндэсний аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлж байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасны дагуу бүрэн ашиглалтад орсон Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээнүүдийг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн улсын комисс ашиглалтад хүлээж авсан зарим төсөл, арга хэмжээ бүрэн хүчин чадлаар ашиглагдаж эхлээгүй байна. Тухайлбал:

- ❖ Сумын хэрэгцээнд универсал трактор /Увс, Цагаанхайрхан сум/
- ❖ Сумын хэрэгцээнд универсал трактор /Увс, Өндөрхангай сум/
- ❖ Сумын хэрэгцээнд универсал трактор /Увс, Зүүнхангай сум/
- ❖ Жуулчдад мэдээлэл өгөх цэг, отоглох талбай байгуулах /Увс, Малчин, Завхан, Наранбулаг, Хяргас, Цагаанхайрхан сум/

Мөн Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуулиар баталсан XVII.3.5 хуулийн дугаартай 2021-2023 онд хэрэгжүүлэх нийт 4,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шинэ хөдөө” төслийн 2021 онд санхүүжүүлэх 650.0 сая төгрөгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн 3 ажлын зарим тоног төхөөрөмж ирээгүй, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй байгаагаас ашиглагдаж эхлээгүй байна. Үүнд:

- Сүү, цагаан идээ боловсруулах цех байгуулах /Өндөрхангай, Улаангом/ гэсэн 440.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний цехийн барилгыг барьсан боловч тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй,
- Мөн төслийн хүрээнд хийгдсэн Жижиг оврын тэжээл боловсруулах цехийн тоног төхөөрөмж 160.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж тоног төхөөрөмж нийлүүлэгдэж ирсэн боловч ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй,
- Ашиглалтын зардал багатай, эрчим хүч, шатахуун зарцуулдаггүй, хэмнэлттэй, инновацын шийдэлтэй, голоос тариалангийн талбай руу ус шахах төхөөрөмж худалдан авах 50.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж ирсэн боловч ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй байна.

Зүүнговь суманд Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгт ариун цэврийн байгууламж 2021 онд хийгдсэн боловч усаар хангах худаг нь хийгдээгүй байна. Аудитын явцад газар дээр нь үзэж холбогдох ажилтнуудаас тайлбар авч зураг авалт хийхэд худгийн

өрөмдлөг эхэлсэн боловч намар оройтож өрөмдлөг хийх явцад хөлдөлт үүссэн тул ажил зогссон байна.

Б.4.4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг 60 хувьтай, албан шаардлагыг 100 хувьтай хэрэгжүүлжээ.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн 5 зөвлөмжөөс 3 зөвлөмжийн хэрэгжүүлж, 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

№	Зөрчлийн утга	Мөнгөн дүн	Биелэлтийн хувь
1	Төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүдийг худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн албан хаагчдыг томилж байх.	0.0	100%
2	Баруунтуруун, Цагаанхайрхан сумдын Эрүүл мэндийн төв болон Өлгий сумын Цэцэрлэг, Өмнөговь сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн засварын ажилтай холбоотой зөрчлийг арилгуулах.	0.0	100%
3	Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй барилга, байгууламжийг гүйцэтгэгч компаниар хийж дуусгах.	0.0	0
4	Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналтыг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллах.	0.0	0
5	Ашиглалтад орсон 8 барилга, байгууламжийг тухайн ашиглагч байгууллагын хөрөнгийн бүртгэлд тусгуулах.	0.0	100%

/Эх сурвалж: Увс аймаг дахь Төрийн аудитын газрын статистик бүртгэл/

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар 82.1 сая төгрөгийн 4 албан шаардлага өгснийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

/Сая төгрөгөөр/

№	Зөрчлийн утга	Мөнгөн дүн	Биелэлтийн хувь
1	Тариалан сумын Цэцэрлэгт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ирсэн 5248.5 мянган төгрөгийн 3 ширхэг зөөврийн компьютерыг данс бүртгэлд тусгаагүй.	5.2	100%
2	Зүүнхангай сумын Соёлын төвд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ирсэн 2601.4 мянган төгрөгийн 1 ширхэг компьютер, 765.7 мянган төгрөгийн 1 ширхэг принтерийг данс бүртгэлд тусгаагүй.	3.4	100%
3	Өлгий сумын Засаг даргын тамгын газарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ирсэн 71800.0 мянган төгрөгийн үнэ бүхий 34 нэр төрлийн 179 ширхэг компьютер, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг данс бүртгэлд тусгаагүй.	71.8	100%
4	Өлгий сумын Цэцэрлэгт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ирсэн 975.0 мянган төгрөгийн 1 ширхэг ханын шүүгээ, 780.0 мянган төгрөгийн 1 ширхэг баримт бичгийн шүүгээг данс бүртгэлд тусгаагүй.	1.7	100%
Нийт дүн		82.1	

/Эх сурвалж: Увс аймаг дахь Төрийн аудитын газрын статистик бүртгэл/

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Төсвийн тухай хуулиар баталсан хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн явуулсан шинээр хэрэгжүүлэх 57 төсөл, арга хэмжээний саналаас 5 төсөл, арга хэмжээ батлагджээ.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 7 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч захиалагчтай байгуулсан гэрээний хугацаанд гүйцэтгээгүй байна.
3. “Шинэ хөдөө” төслийн хүрээнд 2021 онд санхүүжүүлэх 650.0 сая төгрөгийн эх үүсвэрийг аймгийн Засаг даргын захирамжаар 3 багц ажил болгон задалсан ажлын зарим тоног төхөөрөмж ирээгүй, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй байна.
4. Он дамжин хэрэгжиж байгаа төсөвт өртөг нэмэгдсэн 1 төсөл, арга хэмжээний нэмэгдсэн төсөв нь магадлалаар баталгаажуулж байна.
5. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргатай “Аймагт хэрэгжүүлсэн барилга, байгууламжийн ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээ” 2021 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр байгуулсан байна.
6. Зохиогчийн хяналтыг зураг төсөв боловсруулсан байгууллага аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газартай гэрээ байгуулан гүйцэтгэж байна.
7. Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 2021 онд нийлүүлсэн тавилга хэрэгслээс 4 сумын 8 цэцэрлэгт нийлүүлэгдэх байсан 3 нэр төрлийн 127 ширхэг 20.2 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг бэлтгэн нийлүүлэгч “Долоон болдог” ХХК бэлтгэн нийлүүлээгүй байна.
8. Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуульд Увс аймагт хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 3,060.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг баталсан байна.
9. Шинээр хэрэгжүүлэх зураг төсөв боловсруулах шаардлагатай 19 төсөл, арга хэмжээнээс 2 ажлын зураг төсвийг хууль батлагдахаас өмнө, 17 ажлын зураг төсвийг хууль батлагдсаны дараа боловсруулж, баталгаажуулсан байна.

Холбогдох байгууллагын санал


**УВС АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**
3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165
Утас: 7045-3232, 7045-3262
Цахим шуудан: uvs.onug@gmail.com
Цахим хуудас: www.uvs.gov.mn/onug
2022.04.29 № 96
танай 2022.04.27 ны № 347 -т

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлантай төсөлтэй
танилцлаа.

Тайланд тусгуулах санал байхгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГЭЙГ
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ё.МӨНХЗУЛ

D/Албан бичиг/ A5.docx
811210071

**Холбогдох байгууллагын ирүүлсэн
саналд өгөх тайлбар**

Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлд аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас санал ирүүлээгүй тул тайлангийн төсөлтэй санал нэг байн гэж үзлээ. Мөн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 96 албан бичгээр тайланд тусгах санал байхгүй гэсэн хариу ирүүлсэн тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:

Увс аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт:

1. Гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй төсөл, арга хэмжээнүүдийг хийлгэж хүлээн авах.
2. “Аймагт хэрэгжүүлсэн барилга, байгууламжийн ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээ”-г тайлант хугацааны эхэнд байгуулж байх.

Увс аймгийн Засаг даргад:

3. “Шинэ хөдөө” төслийн хүрээнд нийлүүлэгдээгүй байгаа тоног төхөөрөмжийг гэрээний дагуу гүйцэтгэгчээс бүрэн хүлээн авах, ирсэн тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх.
4. Захиалагч нь зохиогчийн хяналтын гэрээг байгуулж байх.

Боловсрол шинжлэх ухааны газарт:


5. Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтын хүрээнд дутуу нийлүүлэгдсэн тавилга хэрэгслийг хүлээн авч данс бүртгэлд тусгуулах ажлыг зохион байгуулах.

Аудитын дүгнэлтээс дараах саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлж байна.

1. Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуульд Увс аймагт хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 3 төсөл, арга хэмжээг баталсан байна. Иймд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээг төлөвлөн, батлуулж байхыг нэгдсэн тайланд тусгуулах.
2. Боловсрол шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яамны сайдын багцаас орон нутгийн салбар байгууллагад ирүүлсэн хөрөнгийн мэдээллийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт өгдөггүй байна. Иймд салбар яамд болон орон нутгийн хэлтэс, агентлаг, Орон нутгийн өмчийн газрын харилцаа хамтын ажиллагааг сайжруулах талаар нэгдсэн тайланд тусгуулах.
3. Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуулиар баталсан XVII.3.5 хуулийн дугаартай 2021-2023 онд хэрэгжүүлэх нийт 4,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Шинэ хөдөө” төслөөр хэрэгжүүлэх ажлын нэр, байршил, хүчин

чадлыг тусгаагүй байх бөгөөд Монгол улсын Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолоор 2021 онд санхүүжүүлэх 650.0 сая төгрөгийн эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна. Эрх шилжүүлсний дагуу аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/235 дугаар захирамжаар "Шинэ хөдөө" төслийн 2021 онд санхүүжүүлэх эх үүсвэр 650.0 сая төгрөгийг 4 багцад задалж нэр, байршил, хүчин чадлыг тусгаж баталсан байна. Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуульд төсөл нэрээр баталж орон нутагт эрх шилжүүлснээр орон нутгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч задалж байгаа асуудлыг УАГ-ын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлж байна.

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ТЭЗҮ, зураг төсөв хийгдсэн ажлыг төлөвлөн батлуулж байхыг нэгдсэн тайланд тусгуулах.

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР  М.БАТ-АМГАЛАН

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР  Т.НАМЖИЛ

АУДИТОР

 Б.ОДГЭРЭЛ

 Т.АМАРМЭНД